



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Соёл Урлагийн Их Сургууль,
Хөгжмийн Урлагийн Сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: “Дуулах урлаг” бакалаврын сургалтын
хөтөлбөр

Индекс: 021503

Шинжээчийн баг:

Ахлагч: Ц.Дэлгэрсайхан /Ph.D/ - МУБИС-ийн Багшийн сургууль

Гишүүд: Ч.Чинзориг /Ph.D/ - Монгол улсын Консерваторийн
Дуулаачийн тэнхимийн эрхлэгч

Ш.Цогтгэрэл /Ph.D/ - Үндэсний батлан хамгаалах их сургуулийн
Цэргийн хөгжмийн сургуулийн багш

Он сар өдөр: 2019.05.29

Товчилсон үгийн тайлбар	4
I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга.....	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт.....	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа.....	11
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	15
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	19
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	24
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа.....	29
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	34
V. Оролцогчдын нэрс	41
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.....	41
II. Оюутны нэр.....	41
III. Ажил олгогч.....	41
IV. Төгсөгчид.....	42
VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....	
VII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	
VIII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	

Товчилсон үгийн тайлбар

- АНУ-Америкийн Нэгдсэн Улс
- АБД-Ардын богино дуу
- АЖ-Ардын Жүжигчин
- АШУ-Анагаахын шинжлэх ухаан
- АЖГ-Аялал, жуулчлалын газар
- БНХАУ-Бүгд Найрамдах хятад ард улс
- БУБ-Багш урлагийн боловсрол
- БШУЯ-Боловсрол Шинжлэх ухааны яам
- БСШУСЯ-Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, соёлын яам
- БТА-Боловсролын тэргүүний ажилтан
- БНСУ-Бүгд Найрамдах Солонгос Улс
- БНХАУ-Бүгд Найрамдах Хятад Ард Улс
- БУС-Бүжгийн урлагийн сургууль
- ДБЭТ-Дуурь Бүжгийн Эрдмийн Театр
- ДУТ-Дуулах урлагийн тэнхим
- ДБУМС-Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем
- ДУ-Дуулах урлаг
- ЕБС-Ерөнхий боловсролын сургууль
- ЗХШҮГ-Захиргаа, хяналт, шинжилгээ үнэлгээний газар
- ЗГХА-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
- МУУГЗ-Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн
- МУГЖ-Монгол улсын гавьяат жүжигчин
- МУГБ-Монгол Улсын Гавьяат Багш
- МУЗ-Монголын Урлагийн Зөвлөл
- МАУД-Монгол Ардын уртын дуу
- МУАЖ-Монгол Улсын Ардын жүжигчин
- МУСГЗ-Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн
- МУБИС-Монгол Улсын Боловсролын их сургууль
- МУК-Монгол Улсын Консерватор
- ӨМӨЗО-Өвөр Монголын Өөртөө засах орон
- СУИС – Соёл Урлагийн Их сургууль
- СБЗГ-Сургалтын бодлого, зохицуулалтын газар
- ЭЕШ- Элсэлтийн Ерөнхий Шалгалт
- ЭШ-Эрдэм шинжилгээ

I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	МУ-ын СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Дуулах урлаг	
Индекс	021503	
Шинжээчид	<p>Ахлагчийн нэр, ажил, албан тушаал:</p> <p>1. Ц.Дэлгэрсайхан- МУБИС-ийн Багшийн сургуулийн захирал</p> <p>Гишүүдийн нэр, ажил, албан тушаал:</p> <p>2. Ч.Чинзориг- МУ-ын Консерваторийн тэнхимийн эрхлэгч</p> <p>3. Ш.Цогтгэрэл - ҮБХИС-ийн Цэргийн хөгжмийн сургуулийн багш</p>	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Зохицуулагчийн нэр, албан тушаал - Б.Мядагмаа- БМИҮЗ-ийн мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Зохицуулагчийн гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
		БМИҮЗ-ийн гаргасан хуваарийн дагуу ажиллав.
		Шинжээчийн багийн ажилласан хуваарийг хавсаргав.
Шалгуур шаардлага /журам/		

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

1964 онд Монгол улсын хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин Г.Хайдавын санаачилга, Соёлын яамны орлогч сайд Ч.Лодойдамбын дэмжлэгээр Засгийн газрын тогтоолоор Дуурь бүжгийн театрын дэргэд мэргэжлийн дуучин бэлтгэх студи

1969 онд Улсын багшийн дээд сургуульд дуулаач, хөгжмийн зохиолчийн анги

1983-1984 оны хичээлийн жилээс дээд боловсролтой уртын дуучин бэлтгэх сургалт /биеийн тамир урлагийн факультетын харьяа найрал дууны ангийн 3 оюутныг Ардын жүжигчин Н.Норовбанзад, багш Л.Даваахүү нарын санаачилгаар уртын дууны мэргэжил эзэмшүүлэх сургалтын шав тавигдсан/

1990 оны 6 сарын 8-ны өдрийн СНЗ-ийн тогтоол № 292-оор Ардын боловсролын яамны харьяа Соёл урлагийн дээд сургуулийн Дуулаачдын тэнхим,

1994 оны 7 сарын 21-ний өдрийн ШУБСайдын №174 тоот тушаалаар Урлагийн үндэсний их сургууль

1996 оны 8 сарын 16-ны өдрийн ШУБ-ын сайдын № 201 тоот тушаалаар Соёл урлагийн их сургууль –дуу хөгжмийн факультет

1996 оны 11 сарын 12-ны өдрийн Гэгээрлийн сайдын 126 тоот тушаалаар Эстрадын дууны анги

1998 оны 5 сарын 20-ны өдрийн Гэгээрлийн сайдын №119 тоот тушаалаар Хөгжмийн урлагийн факультетын дуулаачийн тэнхим, Хөгжмийн онолын тэнхимд эстрад дууны ангийг харьяалуулсан.

2010 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 тоот “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын зарим байгууллагыг өөрчлөн байгуулах тухай” тогтоолоор соёл урлагийн чиглэлийн сургуулиуд нэгдэв.

2011-2012 оны хичээлийн жилд Ардын богино дууны анги тус тус нээгдэж сургалтын үйл ажиллагаа эхэлсэн байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/
- Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тогтвортой хөгжлийн боловсрол-2030, ЮНЕСКО- Бүх нийтийн зөвлөмж, XXI зууны суралцагчийн эзэмших чадвар, чадамж, Инчоны тунхаглал, СУИС болон Хөгжмийн урлагийн сургуулийн эрхэм зорилго, чиг хандлагыг баримжаалан боловсруулсан. /Урлаг судлал, урлагийн боловсролын төрлүүдийн уялдаа нягтарших, хөгжим, дүрслэх урлаг, бүжиг, жүжиг, сонгодог болон үндэсний урлагийн нэгдмэл байдлыг хангах шинэ хандлага/
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан /МУ-ын хэмжээний бүх мэргэжлийн урлагийн байгууллага, театр чуулгууд/ 2019 онд судалгаа хийж, нийт 31 театр, чуулгад 436 дуучин ажиллаж байгааг тогтоож, улмаар тэдний 85.5 хувь нь бакалаврын, 1.8 хувь нь магистрын түвшний боловсролтой, мэргэжлийн бус дуучин 14.5 хувийг эзэлж байгаа зэргийг тэдний орон нутгийн харьяаллаар нь илрүүлэн судалжээ.
- Дуулах урлаг бакалаврын хөтөлбөрөөр 1991 оноос 2018 он хүртэл нийт 915 оюутан төгссөн нь сургуулийн нийт төгсөгчдийн 35.2 хувийг эзэлж байна. Нийт төгсөгчдийн 861 төгсөгч буюу 93% нь “төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-д хамрагдсан бөгөөд 483 төгсөгч буюу 56% нь эрхэлсэн ажилтай, 256 төгсөгч буюу 29.7% нь чөлөөт уран бүтээлч, 104 төгсөгч буюу 12% нь

хувиараа бизнес эрхэлдэг, 20 төгсөгч буюу 2.3 нь суралцаж байгаа, 25 төгсөгч буюу 2.9% нь тодорхой эрхэлсэн ажилгүй байна.

- ОХУ-ын Гнесиний нэрэмжит урлагийн академи, ОХУ-ын М.И.Глинкийн нэрэмжит хөгжмийн дээд сургууль, Итали улсын Венеци хотын “Benedetto Marcello” хөгжмийн дээд сургуулийн хөтөлбөрүүд дэх агуулгын ерөнхий харьцуулалт, ноогдох цаг, эзлэх хувь хэмжээг жишсэн байна. Дотоодын хөтөлбөрийн тухайд Сити дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөний кредит хуваарилалтыг өөрийн сургуулийн хөтөлбөртэй харьцуулжээ.

Анхаарах асуудал:

- Тайлангийн 5-р хуудсанд “Одоо хэрэгжүүлж буй хөтөлбөр нь ELIA –гийн (Европын улс орнуудын хөгжмийн сургуулиудын мөрддөг тохируулах хөтөлбөр)-ийн загварын дагуу боловсруулсан...”, 11-р хуудсанд “...Гадаадын болон дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулснаар Дуулах урлаг хөтөлбөрийг ЮНЕСКО-гийн хөтөлбөрт тавигдах шаардлага, индекс, ELIA-ийн тохируулагч хөтөлбөр (tuning)-ийн дагуу боловсруулсан. Европын аль нэг сургуульд суралцахад кредит шууд тооцох боломжтой” гэх зэрэг үг, өгүүлбэрүүдийн утга агуулга, тайлбар нь тодорхой бус байна.

Зөвлөмж:

- Тайлангийн 10-р хуудсанд “...гадаадын ижил төстэй сургуулийн сургалтын хөтөлбөрийг өөрийн хөтөлбөртэй шууд харьцуулах боломжгүй, хичээл бүрийн агуулга нэг бүрчлэн ил бус байгаа нь хүндрэл учруулж байлаа” хэмээжээ. Ийм тохиолдолд тухайн сургуулийн багш, удирдлагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ хэлэлцээр байгуулах, мэргэжилтэн, багш, оюутан солилцох, хамтарсан сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурал, хамтарсан урлагийн тоглолт, үзэсгэлэн гаргах гэх мэт олон арга хэлбэрээр хамтын ажиллагааг өрнүүлэн, туршлага судлах боломжтой байж болно. Мөн өөрсдөө санаачилга гарган, дотоод, гадаадын ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлж байгаа сургуулиудын багш, оюутнуудын дунд “Дуулах урлаг” хөтөлбөрийн шинэчлэлийн асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн зохион байгуулах гэх мэтээр хөтөлбөрийн шинэчлэлдээ бодитой дүн шинжилгээ хийх нь зүйтэй.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл /Туршлага:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилго СУИС-ийн болон ХУС-ын эрхэм зорилготой уялдуулан, “ерөнхий утгаараа үндэснийхээ уламжлалт урлагийг эрхэмлэн дээдэлж, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх ур чадвар, бүтээлч сэтгэлгээтэй, оюуны өндөр чадамжтай, олон улсын түвшинд нийцсэн дуучин, уран бүтээлч бэлтгэх нэгэн зорилгод хүрсэн” хэмээн дүгнэсэн байна.
- МУ-ын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулийн боловсролын зорилгод нийцүүлэн, “Дуулах урлаг” хөтөлбөрийн зорилтуудыг тодорхойлжээ.
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлохдоо ажил олгогч, сонирхогч талуудын саналыг тусган сургалтын үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийж байна.
- Суралцагчид болон төгсөгчид нь сургууль, багш нартайгаа байнгын эргэх холбоотой ажилладаг нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, өөрчлөлт нь харилцан хамтын үйл ажиллагаанд суурилдаг болохыг гэрчилнэ.

Анхаарах асуудал:

- “Дуулах урлаг” хөтөлбөрөөр төгсөгчийн загвар нь сургалтын хөтөлбөрийнхөө зорилго, зорилт, хүрэх үр дүнтэйгээ хэрхэн уялдаа холбоотой нь тодорхой бус байна. Төгсөгчийн загвар дахь нэр томьёо нь ямар утга агуулгатай гэдэг нь ойлгомжгүй байна. Жишээ нь “Авьяаслаг элсэгч” гэдэгт ямар шалгуур шаардлага байгаа болон “Идэвх зүтгэлтэй оюутан” байх гэдэгт юуг ойлгох, “Дуулах урлаг” хөтөлбөрөөр “Бүтээлч сэтгэлгээтэй төгсөгч” бий болох гэдэгт оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагаар хэрхэн тодорхойлогдож байгаа зэрэг нь бүрхэг байна.

Зөвлөмж:

- Дуулах урлаг сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага төлөвшилтэй хэрхэн уялдаатай байгаа болон энэ нь тухайн хичээл бүрийн зорилго, зорилттой мөн хэрхэн уялдаатай байгаа эсэхэд сайтар дүн шинжилгээ хийж, энэ талаар багш нарт арга зүйн сургалт, зөвлөгөө тогтмол өгдөг байх хэрэгтэй.

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Батлагдсан хөтөлбөр
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл /Туршлага:

- БСШУ-ны сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу “Дуулах урлаг” багцалсан хөтөлбөрийг боловсруулсан.
- БШУЯ-наас гаргасан “Сургалтын баримт бичиг боловсруулахад баримтлах журам” болон бусад эрх зүйн баримтыг үндэслэн хөтөлбөрийн баримт бичгийг бүрдүүлэн ажиллаж байна.
- Дуулах урлаг хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр хөтөлбөр боловсруулан, ХУС-ийн эрдмийн зөвлөлөөр баталгаажуулан мөрддөг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн дэд хороо ажилладаг гэх боловч хэлэлцэж, баталгаажуулсан баримт дутмаг байна.
- Сургалтын стандарт, хөтөлбөрийг нэг багш дангаар боловсруулсан буюу бусад багш нарын нэр хөтөлбөрт огт дурдагдаагүй байгаа байдлыг цаашид анхаарах. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш бүр хөтөлбөрийн шинэчлэлд гар бие оролцсон л бол “Хөтөлбөр боловсруулсан багш” гэдэгт нэрээ оруулах /гарын үсэг зурж баталгаажуулах/ нь зүйтэй юм.
- Батлагдсан хөтөлбөр нь зөвхөн Сургалтын албанд байх бус хөтөлбөр хэрэгжүүлэгч багш бүрт нэг, нэг хувь байх шаардлагатай.
- “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу багш бүрийн хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хөтөлбөрийн бүтэц, агуулга, арга зүй, үнэлгээнд тавих шаардлагын дагуу багш нарын мэдлэг, ур чадварыг сайжруулахад анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг шинэчлэхдээ холбогдох мэргэжлийн багш нар болон хөтөлбөрийн албаны мэргэжилтний мэдлэг, ур чадварыг тасралтгүй сайжруулах хэрэгтэй.

1- р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл / Туршлага

- Дуулах урлаг хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийж, хичээл хоорондын хамаарлыг харгалзан үзэж, Ерөнхий суурь, Мэргэжлийн суурь, Мэргэжлийн хичээлийн гэсэн 3 багцаар боловсруулжээ.
- 2011 оноос СУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд сургалтын бүх үйл ажиллагааг UNICULTURE системд оруулснаар оюутан бүр өөрийн суралцах үйл явцыг хянахаас гадна хичээл, өдөр, цаг, багшаа сонгох, төлөвлөлт хийх бүрэн боломжтой болжээ.
- Заавал судлах болон сонгон судлах хичээлийн кредит цагийн харьцаанд дүн шинжилгээ хийж, мөн “Дуулах урлаг” хөтөлбөрөөр төгсөгчдөөс судалгаа авсны үр дүнд хөтөлбөрт өөрчлөлт хийхдээ дадлага давамгайлсан сургалт явуулах зорилгоор дуулаачийн цөөхүүл хичээлийг хөтөлбөрт шинээр оруулжээ.

- Сургалтын үйл ажиллагаа нь лекц, семинар, ганцаарчилсан, дадлага гэсэн хэлбэрээр явагддаг ба онол, практикийн харьцааны хувьд лекц 70 кредит /танхимаар/, 13 кр нь ганцаарчилсан хичээл, 46 кр нь бүлгээр орох соноршуулга, бүжиг, дуулаачийн цөөхүүл хичээлүүд, 3-р дамжаанаас үйлдвэрлэлийн дадлага мэргэжлийн урлагийн байгууллага, оюутан театрт тавигдсан бүтээлүүдэд оролцох гэх мэтээр практик давамгайлсан сургалтын хэлбэрээр явагдаж байна.
- Дуулах урлаг хөтөлбөрөөр суралцагчид нь нийслэл болон аймгуудын мэргэжлийн урлагийн байгууллагад дадлагажихын зэрэгцээ уран бүтээлийн судалгаа хийх ажлыг хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай.
- Дуулах ур чадвар хичээлийн кредитийг нэмэгдүүлснээр оюутнууд олон улсын уралдаан, тэмцээнд амжилт үзүүлж байгаа үр дүн гарчээ.
- Суралцагчийн хичээл, багшийг сонгон суралцаж байгаа байдал, сургалтын төлөвлөгөөний өөрчлөлт зэргийг 2011, 2014 оноор харьцуулан, дүн шинжилгээ хийжээ.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн цагийн ачааллыг хэрхэн тооцдог судалгаа дутмаг байна.

Зөвлөмж:

- Хичээл хоорондын залгамж холбоог хичээлийн нэр нэршлээр ерөнхийлөн зураглал гаргахаас гадна хөтөлбөрөөр суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн уялдаа холбоогоор хичээлүүдийн залгамж холбоог тодорхойлох нь илүү үр дүнтэй.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын арга зүйд хийсэн анализ судалгааны баримт материал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дуулах ур зүйн онол, арга барилыг эзэмшүүлэх дасгалуудыг долоон хоногт 2-3 удаа ганцаарчлан ажиллана. Мастер класс, сургалтын дадлага ажлуудыг зохион байгуулдаг.
- Оюутанд судалгааны ажлын арга зүй эзэмшүүлэх зорилтын хүрээнд жил бүр төгсөлтийн бичвэрийн ажил бичүүлж, судалгааны арга зүй эзэмшүүлэхээр

зорьж байгаа нь сайшаалтай. Судалгааны ажлын сэдэв, чиглэл нь дуулах арга барил, дүр судлал, дуучны мэргэжлийн онцлог, дуучны мэргэжлийн эрэлт хэрэгцээ зэрэгт чиглэгдэж байгаа нь хөтөлбөрийн зорилго хийгээд суралцагчийн цогц чадамж, суралцагч төвтэй байна хэмээн үзэж байна.

- Багш нарын үзүүлэх хичээлд анализ хийж, онцлогийг хүснэгтээр тодорхойлсон байна.
- Дуулах урлаг хөтөлбөрийн хичээлүүдийн сургалтад хэрэглэж буй аргуудыг түүвэр судалгаагаар нэгтгэн судалсан байна.
- Багш нарын багшлахуй, арга зүйг хөгжүүлэх зорилгоор төслийн болон мэргэжлийн сургалт, семинар, эрдэм шинжилгээний хуралд хамруулсан тухай баримт материалыг тайланд он цаг, гүйцэтгэгчтэй нь харуулсан байна. /тайлангийн 27-28-р хуудсанд/

Анхаарах асуудал:

- Сургалтын арга, сургалтын хөтөлбөрийн арга зүй хэмээх ойлголтыг сайтар ялган таньж мэдэхгүй байгаа байдал өөрийн үнэлгээний тайлан болон сургуульд багш нартай уулзаж, ярилцах явцад анзаарагдлаа.

Зөвлөмж:

- Багш нарын сургалтын арга зүй, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн мөн чанарыг сайтар ухаарч ойлгуулах үүднээс боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухааны чиглэлээр мэргэжлийн эрдэмтэн судлаач, багш нараар сургалт-семинар /цуврал байдлаар/ авах, багш солилцох нь зүйтэй.
- Багш нарын үзүүлэх хичээлийг зөвхөн ганц нэгээр нь хичээлийг нь бэлдүүлж, заалгах гэхээсээ илүүтэйгээр багш нарыг хэд хэдэн багт хуваарилан, хамтарч хичээлийг нь бэлдүүлэх, хамтарч хичээлд нь анализ хийлгүүлэх, дахин хичээлийг нь засан сайжруулах зэрэг механизмыг авч хэрэгжүүлэх нь багш нарын арга зүй, ур чадварыг дээшлүүлэхийн зэрэгцээ хичээл дээр мэдлэг бүтээлгэх үйл ажиллагаа багш бүрийн хувьд тодорхой ахиц дэвшил гарч болно.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам

- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар г.м/

Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн Удирдах зөвлөлийн 2014 оны 07-р сарын 02-ны өдрийн 03 тоот тогтоолоор батлагдсан дүрэм, журамд хөтөлбөрийн явцад оюутны мэдлэг, ур чадвар, хандлагын түвшинг хэрхэн үнэлж тогтоохыг заасан байна.
- Үнэлгээний шалгуурт явцын шалгалт 70 оноо, улирлын шалгалт 30 оноогоор дүгнүүлнэ.
- Үнэлгээний шалгуурыг “Ганцаарчилсан хичээлийн дүгнэх байдал” / дуулах ур чадвар, төгөлдөр хуур/, мэргэжлийн суурь болон мэргэжлийн багцад хамаарах хичээлээр оюутныг дүгнэх байдлыг жишээгээр тайланд тайлбар хийсэн байна.
- Шалгалтын дараа багш, оюутан харилцан ярилцаж, хүүхэд тус бүр дээр дүн шинжилгээ хийж, авбал зохих оноонуудын аль дээр нь ямар алдаа гарсныг нь өөрсдөөр нь дүгнүүлж, үнэлгээ хэр бодитой болсныг нь баталгаажуулдаг.
- Харилцан ярилцаж, дүн баталгаажсны дараа дүгнэгдсэн байдалдаа оюутан сэтгэл ханамжгүй байгаа бол өөрийн хүсэлтээр тухайн улиралд R үнэлгээ тавиулж, дараа улиралд дүнгээ ахиулах боломжтой байгаа нь суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангаж байна хэмээн үзэх үндэстэй.
- Оюутнууд өөрийн код бүхий вэб хуудсаараа нэвтэрч, үнэлгээгээ хянах, багшийн үнэлгээ, сургалтын арга зүйн талаар санал асуулгад оролцож, сэтгэл ханамжийн байдлаа илэрхийлэх тогтолцоо бүрдсэн байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүн, хичээл бүрийн зорилго, зорилттой уялдуулан үнэлгээний шалгуур, шаардлагыг улам тодорхой болгох нь зүйтэй. Үнэлгээний хувьд Блумын таксономи, Рубрикийн арга гэх мэт арга, хэлбэрийг судлан, хэрэгжүүлэх тал дээр анхаарах

Зөвлөмж:

- Үнэлгээний тал дээр багш бүрийн ойлголт янз бүр байгаа байдалд дүн шинжилгээ хийж, үнэлгээний чиглэлд мөн мэргэжлийн байгууллага, хувь хүмүүсийг урьж, багш нарыг сургалтад хамруулж, мэдлэг, чадварыг нь дээшлүүлэх нь зүйтэй байна.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лабортори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дуулах урлаг хөтөлбөрөөр суралцагчдын сурах орчинг сйажруулах үүднээс 2012 оноос дуурийн дуу, уртын дуу, ардын богино дууны ангиуд хичээлийн I байрны 2 ба 3 давхарт, эстрадын анги 2014-2015 оны хичээлийн жилд Орчин үеийн хөгжмийн урлагийн тэнхим болон тусгаарлан хичээлийн III байрны 2 давхарт тус тус сургалтын үйл ажиллагаа явуулж байна.
- Сургуулийн үүдний хэсэг, 1 давхарын баруун, зүүн жигүүрийн коридор, анги, танхимын шал, хаалга, хана зэрэгт шинэчилсэн засвар хийж, хөгжлийн бэрхшээлтэй оюутанд зориулсан суултуур зам, шат, орц, гарцын тэмдэг, тэмдэглэгээ, ус цэвэршүүлэгч зэргийг байрлуулсан нь эрүүл, аюулгүй тохилог орчинг бүрдүүлэхэд тодорхой ахиц дэвшил болжээ.
- Хичээлийн I байранд мэргэжлийн суурь хичээл, мэргэшүүлэх хичээлүүд явагддаг ба II байрны 4 танхимд ерөнхий суурь боловсролын хичээл, I байрны 2, 3 давхарт ганцаарчилсан хичээлийн 10 танхим, III байранд 3 танхим, дэд бүлэг, бүлэг хэлбэрээр хичээллэх цахилгаан даралтад хөгжмийн танхим, оюутан театр, концертын бага заал, найрал дуу, дуу хөгжмийн бичлэгийн студи, хөгжмийн лаборатори-урлагийн номын сан, оюутны хөгжил төв, цайны газар, зэрэг оюутны бие даах болон хамтран ажиллах эрүүл, аюулгүй байдлыг хангасан орчин бүрдүүлэн ажиллаж байна.
- Дуулах урлаг хөтөлбөрийн сургалтын анги, танхимын хүрэлцээг сүүлийн 5 жилээр харьцуулан үзэхэд ерөнхий суурь хичээлийн анги танхим болон

ганцаарчилсан хичээлийн анги танхимын хүрэлцээ сайжирсан байна. Тухайлбал, орчин үеийн хөгжмийн урлагийн тэнхимийн ганцаарчилсан хичээлийн 1 өрөөнд 3 багш ээлжлэн хичээл сургалт явуулдаг байсан бол одоо 1 өрөөнд 1-2 багш хичээллэж байна.

- Хичээлийн байр, анги танхимын ашиглалтын үзүүлэлтийг ашиглалтад орсон болон засвар хийсэн он, хүчин чадал, одоогийн ашиглалтын байдал, ашигтай талбайн хэмжээ зэрэг үзүүлэлтээр тодорхой харуулсан байна.
- Дотуур байранд ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүд, лаборатори, анги, танхимын тоног төхөөрөмжийн судалгааг нэр төрөл, тоо хэмжээг сүүлийн 5 жилээр харьцуулан гаргажээ.
- Оюутны дотуур байр болон цайны газрын ашиглалт, хүртээмжийн талаар сэтгэл ханамжийн судалгаа авахад хичээлийн III байрны цайны газарт иж бүрэн засвар хийгдсэн нь сэтгэл ханамжтай байсан ба хичээлийн I байранд цайны газар байхгүй байгаад оюутнууд сэтгэл ханамжгүй байна.
- Дуулах урлаг хөтөлбөрийн сургалт нь ганцаарчилсан болон багаар хамтран ажиллах, бие даан ажиллах орчны хангалт сүүлийн 5 жилд маш сайн өөрчлөгдсөн байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн I байр 1954 онд, хичээлийн III байр 1956 онд тус тус ашиглалтад орсон бөгөөд энэ барилгын насжилтын хувьд онцгойлон анхаарах асуудал болсон байна. Эдгээр барилгад иж бүрэн засвар хийгдээгүй, зөвхөн урсгал засвар л хийгдэж ирсэн байна.

Зөвлөмж:

- Хичээлийн байрны насжилт болон аюулгүй байдлыг хангах хэвийн түвшинд байгаа эсэх талаар барилгын болон инженерийн мэргэжлийн байгууллага, нийслэлийн хот төлөвлөлтийн газар, улсын мэргэжлийн хяналтын газрын барилгын асуудал эрхэлсэн улсын байцаагч нарт албан хүсэлт гарган, тэд нараар шинжээчийн дүгнэлт гаргуулах зайлшгүй шаардлагатай. Улмаар улсын төсөвт хичээлийн байрыг шинээр бариулах, эсвэл хүчитгэл хийлгэх асуудлыг нэн даруй дэвшүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй.

3.2 Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- E-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Компьютерын лабораторийн тоног төхөөрөмжид 2013 онд технологийн бүрэн шинэчлэл хийгдсэн.
- Удирдлагын UNICULTURE системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэдэг бөгөөд сургалтын бүх үйл ажиллагаа тус системээр зохицуулагдаж байна.
- 2014 онд 16 нэр төрлийн тоног төхөөрөмж бүхий дуу хөгжмийн бичлэгийн студийг шинээр нээн ажиллуулж, сургалт, уран бүтээлийн ажилд ашиглаж байна.
- SPSS судалгааны ажлын программ, Sibelius 6, 7, 8 нот бичлэгийн программ, Cubes- студийн программ зэрэг сургалт, судалгааны программуудад 2013 оноос лицензийн шинэчлэл хийсэн. Мөн дуу хөгжим, бичлэгийн студийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэсэн он, зориулалт, тоо ширхэгийн жагсаалтыг тайланд тодорхой тусгасан.
- Сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмжийн хувьд 160 оюутнаас сэтгэл ханамжийн судалгаа авсан байна.
- Сүүлийн 5 жилд хөгжим сонсох, ноот гарын авлагын хүртээмж, хэрэглээ сайжирсан.
- СУИС 2011-2012, 2015-2016 онд сургалтын ажлыг зохион байгуулах дүрэм, журмын эмхтгэлийг шинэчлэн боловсруулсан байна. Үүнд ХУС-ийн Дуу бичлэгийн студийн үйл ажиллагааны журам, Нот бичлэгийн лабораторийн үйл ажиллагааны журам зэргийг дурдаж болно.
- ХУС-ийн дуулах урлагийн тэнхимийн багш нарын нээлттэй хичээлийг дүрсжүүлэн бичиж, Youtube болон СУИС-ийн сайт, ХУС-ийн website, page хуудас, Facebook-т байршуулдаг.

Анхаарах асуудал:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар 160 оюутны 99 нь сэтгэл ханамж дунд зэрэг, 26 нь сэтгэл ханамжгүй гэсэн үзүүлэлт байгааг цаашид анхаарч, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчлэх тал дээр анхаарах нь зүйтэй.

3.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа.

Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн нэгдсэн номын сан нь 518м² талбайтай, 260 суудал бүхий 9 уншлагын танхим, хөгжим сонсголын танхимтай, 58000 гаруй номын фондтой.
- Сургуулийн хэмжээнд бүх номын сангууд үйлчилгээндээ Lib4U PC 1.0 программыг авч ашиглаж байсан бол 2013 оноос КОХА программыг авч ашиглаж байна. Тус программд 60000-аад номын мэдээ, 4000 гаруй уншигчийн мэдээллийг оруулж, электрон католог, уншлага үйлчилгээгээр ханган ажиллаж байна.
- Цахим сан хөмрөгийг бүрдүүлэх зорилгоор нот, эрдэм шинжилгээний бүтээлийг дижитал хэлбэрт оруулах ажил өрнүүлснээр одоогийн байдлаар 2000-аад нот, 600 гаруй магистрын бичвэрийн ажлыг дижитал хэлбэрт оруулжээ.
- 2013 оноос вебэд суурилсан КОХА программ хангамж авч ашигласнаар католог зохион байгуулах, уншигчийн цахим карт нээх, ном олгох, буцаалт зэрэг үйлчилгээний мэдээ, мэдээлэл гаргах зэрэг үйл ажиллагаа нь нэгдсэн нэг системээр явагдах болсон байна.
- СУИС-ийн номын сан нь МНСК-д элссэн бөгөөд номын сангийн олон улсын сүлжээнд нэгдэх асуудлыг судалж байна.
- Annual Reviews, Directory of Access Journals, Directory of Open Access Books, EBSCO host, Art & Architecture Complete, International Bibliography of Theatre & Dance, eBook- Academic subscription collection зэрэг олон салбарын эрдэм шинжилгээний болон мэргэжлийн чиглэлийн мэдээллийн сангуудыг өргөн ашиглаж байгаа нь сайшаалтай байна.
- Мөн ОХУ-ын улсын номын сантай хамтран ажиллах болсноор тус номын сангийн цахим уншлагын танхимын диссертацийн дижитал сан, хөгжмийн бүтээлийн сан, шинжлэх ухааны болон боловсролын ном, гар бичмэлийн сан, зургийн сан зэргээр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн нь томоохон ахиц дэвшил байна.
- Мэргэжлийн сурах бичгийн 2746 ширхэг ном байгаа нь тус хөтөлбөрөөр суралцаж буй 1 оюутанд 13.6 ширхэг ном ноогдож байна.

Анхаарах асуудал:

- Цаашид номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагын үүднээс номын санчдын орон тоог нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилгоор сургалтад тогтмол хамруулж байх.
- Номын сангийн суудлын тоог нэмэгдүүлэх, чөлөөт сонголттой номын сан байгуулах, ном хэвлэлд зориулсан зардлыг нэмэгдүүлэн төсөвлөх, төсөвлөсөн хэмжээнд шаардлагатай мэргэжлийн ном, сурах бичиг, хэвлэлийг худалдан авах
- Номын сангийн үйлчилгээний түргэн шуурхай найрсаг харилцааны тухайд сэтгэл ханамжийн судалгаагаар “хангалтгүй” гэх хариулт 62% эзэлж байгаад дүн шинжилгээ хийж сайжруулах арга хэмжээ авах

Зөвлөмж:

- Номын сангийн үйлчилгээний талаар судалгаанд оролцсон 760 хүний 40 хувь нь электрон каталог ашигладаг, үлдсэн хувь нь мэдэхгүй буюу ихэнхдээ ашигладаггүй гэжээ. Иймд электрон каталогийн танилцуулга, ашиглах зааврыг сурталчлах ажлыг номын санчид болон Хөтөлбөрийн алба, Оюутны хөгжлийн алба, оюутны зөвлөлтэй хамтран зохион байгуулах нь үр дүнтэй.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө.
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ

Шалгуурыг хангасан байдал:Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ын захирлын 2015 оны 06 сарын 11-ны А/192 тушаалаар “Дуулах урлаг” хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороог байгуулж эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн баталсан. Дараа нь Дорно дахины хөгжим судлал /Тэргүүлэх профессор С.Соронзонболд/, мэргэжлийн хөгжим, урлагийн боловсрол судлал /Н.Жанцанноров/ гэсэн 2 чиглэлээр профессорын баг байгуулж ажилласан.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг гаргаж 2017 онд гарын авлага болгон нэгтгэж хэвлэсэн. Улмаар хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, мониторинг, үнэлгээ хийх, шалгуур үзүүлэлтийг боловсруулж түүнийхээ дагуу багш нарын аттестатчилал, мэргэжлийн хяналтын албаны дотоод мониторинг, төгсөгчдийн дүн, диплом хэвлэлтэд мониторинг хийх гэх мэт тодорхой ажлуудыг хэрэгжүүлсэн.
- Сургуулийн байранд “Гомдол, санал хүсэлт, баярлалаа” гэсэн 3 хайрцаг тогтмол байрлуулж зохих ёсоор шийдвэрлэдэг.
- Удирдлагын мэдээллийн систем UNICULTURE-ийг ашиглаж, сургалтын үйл ажиллагааны жигд тогтвортой байдал, багш оюутны ажлын уялдаа холбоог зохицуулж, улмаар *Suis.edu.mn/teacherweb* программаар багшийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, *198.168.20.2/student* вебээр оюутантай холбоотой үйл ажиллагааг зохицуулж, *elselt.msuac.edu.mn* сайтаар элсэлтийн бүртгэлүүдийг хийдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн сургалтын чанар, үр дүн, хөтөлбөрөө тасралтгүй сайжруулах, шинэчлэх үйл ажиллагаанд багш нарын оролцоог жигд хангах байдал учир дутагдалтай байна. Тиймээс багш бүр цаашид юу хийх, ямар асуудалд анхаарч ажиллах тухай богино хугацааны төлөвлөгөө, тайлан хийх. Өөрөөр хэлбэл, сургуулийн урт ба дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулсан сарын ажлын төлөвлөгөө, тайланг тогтмол хийж хэвшин, сар бүр багш нарын ажлын тайланг дүгнэж хэлэлцсэн тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэлийг хөтөлж зохих арга хэмжээ авч байх шаардлагатай нь харагдлаа.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж байгаа СУИС-ын ХУС-болон хэрэгжүүлэгч нэгж болох “Дуулах урлагийн тэнхим” нь багш нараа эрдэм

шинжилгээ судалгааны ажилд татан оролцуулах, тэднийг идэвхжүүлэхэд анхаарах.

- UNICULTURE мэдээллийн системийг тогтмол, доголдолгүй ажиллуулж, сургалтын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цаг тухайд нь хүргэхэд анхаарах
- Сургалтын төлөвлөгөө, оюутны гарын авлага жил бүр өөрчлөгддөг, зарим тохиолдолд багш байхгүй гээд хичээл сонгох боломжгүй болох, багш нар оюутнуудын дүнг дутуу эсвэл буруу оруулснаас оюутан хохирдог гэх зэрэг оюутнуудын зүгээс гаргасан санал гомдлыг барагдуулахад анхаарал хандуулах нь зүйтэй.

4.2 Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дуулах урлаг хөтөлбөрийн хүрээнд 10 гаруй төсөл хэрэгжүүлсэн байна. Эдгээрээс Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтран “Шведийн музейд хадгалагдаж байгаа монгол ардын мартагдсан дуу, хөгжмийг сургалт, судалгаа, уран бүтээлийн эргэлтэд оруулах” төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна.
- БНХАУ-ын 3 дээд сургуульд 4 багш, зочин профессороор ажиллаж мөн тэндээс 4 багш ирж сургалтанд хамрагдсан ба 1 багш, 1 оюутан ЗГ-ын тэтгэлэгээр ОХУ-д, 1 оюутан, оюутан солилцоогоор суралцсан байна.
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээ нь олон улсын чуулган, ЭШХ, симпозиум, хэлний сургалт, туршлага судлах, мэргэжлийн уралдаан зэрэг ажлуудаар

явагдсан байна. Жил бүр Улсын баяр наадмын үеэр 7 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Монголын үндэсний соёл урлагийг гадаад, дотоодын иргэдэд сурталчлах, баяр наадмын соёлын үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор “Нүүдэлчний соёл урлагийн наадмыг Хүй долоон худаг-т томоохон бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулдаг нь сайшаалтай.

Анхаарах асуудал:

- Дуулах урлаг хөтөлбөрийн хүрээнд дотоодын ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг их, дээд сургуулиудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг баримтжуулах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн үндсэн орлого буюу сургалтын төлбөрөөс 2014 онд 796.912.836.60₮, 2015 онд 825.535.909.14₮, 2016 онд 905.890.716.11₮, 2017 онд 903.514.717.15₮, 2018 онд 860.215.979.24₮ орсон байна. Үүнийг багшийн цалин, оюутныг хөгжүүлэх ур чадварын уралдаан, тэмцээн, дадлага, сургалт, семинар болон бусад зардалд зарцуулдаг байна.
- Дуулах урлаг хөтөлбөрт суралцагсдын төлбөр төлөлт 2014 онд 2.238.090, 2015 онд 2.388.803, 2016 онд 2.412.981, 2017 онд 3.004.158, 2018 онд 3.608.075 гэх мэтээр жил бүр нэмэгдсэн байна.
- Санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар санаачилга гарган ажилладаг, төсвийн тодорхой хувь нь багшийн хөгжлийг дэмжих сургалт, томилолт зэрэг ажилд зарцуулагддаг ба нэг суралцагчид оногдох өртөг зардал тооцож төсөвлөдөг сүүлийн жилүүдэд энэ зардал нь тогтмол нэмэгдэж байгаа.

- Багш нарын аттестатчилалаар өндөр үнэлгээ авсан багш нарыг цалингийн тодорхой хувиар урамшуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт, Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтыг илүү тодорхой байлгаж ил тод тайлагнаж байх.

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааг тодорхой давтамжтай явуулах, үр дүнг харьцуулан шинжлэх, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах
- Төсөл хөтөлбөрүүд, тоглолтын орлого, хандив, богино хугацааны сургалт, ном, гарын авлагын орлогын зарцуулалтын тайланг нээлттэй, тодорхой байлгах

4.4 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, баримт

Шалгуурыг хангасан байдал:Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дуулах урлагийн мэргэжлийн орон тооны судалгааг жил бүр аймаг хотуудын боловсрол, соёл урлагийн газрууд, УБ хотын мэргэжлийн урлагийн байгууллагуудаас авдаг юм байна. Эрэлт ихтэй аймгуудад багш томилон элсэлт авах, сургалт, семинар, тэнхимийн нээлттэй өдөр, ТВ-ийн нэвтрүүлэг, ярилцлагад оролцох зэрэг мэргэжил сурталчлах ажил явуулсан байна. Мөн хос хөтөлбөрөөр хичээллэх боломжтой болсон байна.

Анхаарах асуудал:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны мэдээлэл, тоо баримтад нарийвчилсан шинжилгээ хийж, төгсөгчдийн ажиллах боломжтой ажлын байруудад тавигдах шаардлага, шалгуурыг хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулахад анхаарах

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгаанд дүгнэлт хийж жил бүрийн судалгааны үр дүнг харьцуулан шинжлэх, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах
- Оюутнууд дуурийн театрт дуурь үзэх хүсэл их байгаа ч санхүүгийн боломжгүйгээс чадахгүй байна гэж ярьсан тул Дуулах урлагийн хөтөлбөрөөр

суралцагчдад Дуурийн театрт хөнгөлөлтэйгээр дуурь үзүүлж байх боломж гарцыг судлан хэрэгжүүлэх

- Оюутнууд анги танхимын хүрэлцээ муу, тайзан дээр сургуулилах боломж байдаггүй талаар гомдол санал гарч байсан тул үүнд анхаарал хандуулж, асуудлыг зохистой шийдвэрлэх гарц гаргалгааг олох

4.5 Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Веб сайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дуулах урлагийн хөтөлбөрийг СУИС-ийн веб сайтад нээлттэй ил тод байрлуулдаг.
- Тэнхимээс зохион байгуулж буй урлаг, соёлын арга хэмжээг ТВ, радио, сонин хэвлэлээр цацаж сурталчилдаг байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн буюу ХУС, дуулах урлагийн тэнхимээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалтыг тусгайлан хийх

Зөвлөмж:

- Дотоод мэдээллийн системийг өргөжүүлж, интернэтийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журам
- Элсэгчдийн ЕШ-ын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа.
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрт элсэгч нь бүрэн дунд түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх, ЭЕШ-ын босго оноо 480 байна гэжээ. Мөн дуулах ур чадварын шалгалт авдаг. СУИС-ийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллеж, “Бадмаараг” ахлах сургууль, Монгол улсын консерваторийг төгсөгчид нь ур чадварын шалгалт өгөхгүйгээр элсэх боломжтой байна.
- Шинээр хөтөлбөрт элсэн суралцагчдад зориулсан “Оюутны гарын авлага” тараадаг.
- Тайлант хугацаанд хөтөлбөрт элсэгч гадаад оюутны тоо 95 байна.

Анхаарах асуудал:

- Дуулах урлаг хөтөлбөрөөр тайлант хугацаанд элсэгчдийн нийт тоог 368, 237, 446 гэж 3 өөрөөр, төгсөгчдийн тоог 307, 321 гэж 2 өөрөөр гаргаж өгснийг анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан болон элсэн суралцагчдын тооны харьцааг гаргаж дүгнэн, цаашдын үйл ажиллагаандаа тусгах.
- Хөтөлбөрт элсэгчдийн элсэлтийн шалгалтын нэгдсэн дүнгээр бие даасан мэдээллийн сан үүсгэх.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал:Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны гарын авлагад сургалтын нэгдсэн график, сургалтын төлөвлөгөө, бакалаврын сургалтын журам, оюутанд санал болгох төлөвлөгөөг нэгтгэсэн байдаг.
- Оюутнаас сэтгэл ханамжийн судалгааг “Сургуулийн үйл ажиллагааны тухай”, “Сургалтын хөтөлбөр, технологи, оюутны үйлчилгээний тухай” гэсэн үндсэн 2 чиглэлээр нийт 42 асуултаар авдаг.
- Оюутны ЭШХ-ыг жил бүр зохион байгуулдаг. Эрдэмтдийн уншсан лекц, семинар болон тус сургуулийг төгсөөд амжилттай ажиллаж байгаа уран бүтээлчидтэй уулзалт, ярилцлага, сургалт зэргийг зохион байгуулж, ирээдүйд сайн уран бүтээлч болох хүсэл мөрөөдлийг нь дэмжиж ажилладаг.

Анхаарах асуудал:

- Оюутны нийгмийн асуудал хариуцсан орон тоог бий болгосон гэж тайланд тусгасны дагуу нийгмийн ажилтантай уулзах хүсэлт гаргахад байхгүй байсан.
- Зөвлөх багшийн үйл ажиллагааг чанаржуулж, оюутнуудыг сэтгэл ханамжтай болгох.

Зөвлөмж:

- Оюутны зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, оюутнуудад тайлан мэдээлэл тавьдаг байх
- Оюутны ЭШХ-ын үр дүн, ач холбогдлыг сайжруулахад анхаарч, нийт суралцагсдын оролцоог нэмэгдүүлэх, судалгааны ажилд амжилт гаргасан тохиолдолд зөвхөн оюутан бус удирдаж ажилласан багшийг хамтад нь урамшуулах тогтолцоог бий болгох

5.3.Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оюутны клубын зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл.
- Олимпиад, уралдаан тэмцээнд оролцсон суралцагчийн тоо, үр дүнгийн мэдээлэл
- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо

Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дуулах урлаг хөтөлбөрөөр суралцагсад нь “Хотын гудамж миний нутаг-бид сайн сайханд дагуулна” олон нийтийн өргөн зугаалгыг тогтмол зохион байгуулдаг. Мөн III, IV курс төгсөх ангийн оюутнууд ЕБС, цэцэрлэгийн урлаг, соёлын ажлыг зохион байгуулахад оролцдог байна.
- Ари романс дуулаачдын уралдаан, уртын дуу дуулаачдын уралдаан, “Лавай” дуурийн дуулаачдын уралдаанд оюутнууд тогтмол оролцдог.
- Тайлант хугацааны 5 жилд зээл, тусламж, тэтгэлэгт нийт 118 оюутан хамрагдсан.

Анхаарах асуудал:

- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйг дээшлүүлэх, суралцагчийн сайн дурын ажлыг үнэлэх чиглэлээр тодорхой ажлыг хэрэгжүүлэхэд ХУС, дуулах урлаг тэнхимээс тодорхой анхаарах
- Оюутны клубын үйл ажиллагааг тогмолжуулах

Зөвлөмж:

- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан оюутны тоог нэмэгдүүлэх

5.4 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг СУИС-ийн бакалаврын шилжилт хөдөлгөөний журмын дагуу шийдвэрлэнэ. Тайлант хугацаанд 23 оюутан шилжин ирсэн.
- Хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын консерватороос шилжиж ирсэн оюутны төлбөрийн 70%-ийг хөнгөлөх, шалгалтаа шууд өгөөд багц цагийг тооцуулж болохоор зохицуулсан байна.
- Шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ сургуулийн хүрээнд мөрдөгдөж буй дүрэм, журмыг хэрэгжүүлж, суралцагчийн эрх ашгийг дээдлэхэд анхаардаг.

- Ажил олгогч байгууллагуудтайгаа тогтмол хамтарч ажилладаг. Тэд дуулаачийн хөтөлбөрөөр суралцаж төгсөгчдийн ур чадвар сайжирсан гэж үзсэн.

Анхаарах асуудал:

- Элсэгчид, төгсөгчдийн тооны зөрүү их байгаа тул нэгэнт элсэн орсон суралцагчдыг сонгосон хөтөлбөрөөр нь амжилттай суралцах гарц, боломжийг хайж хэрэгжүүлэх

Зөвлөмж:

- Сургалтын төлбөр төлөх боломжгүй сургуулиас гарах, жилийн чөлөө авч буй оюутнуудыг зээлийн санд хамруулах, судалгааны төсөлд ажиллуулах тогтолцоог бүрдүүлэх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн захирлын 2015 оны 6 сарын 5-ны өдрийн тушаалаар “Төгсөлтийн журам”, 2017 оны 6 сарын 13-ны тушаалаар “Төгсөлтийн ёслолын хувцас, түүнийг хэрэглэх журам” батлагдсан.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын зүгээс Дуулах урлаг хөтөлбөрөөр төгсөгчид нь “би”-гийн сэтгэлгээ өндөр, “Од” болох хүсэлд хөтлөгдсөн, бусдыг хүндэтгэх ёс зүйн төлөвшил дутмаг, ардын дуугаар төгсөгчид нь өөр урлагийн байгууллагад очоод, ардын дуунаас өөр дуу дуулж чадахгүй байна зэрэг алдаа дутагдлын талаар шүүмжилж байсныг цаашид анхаарах

Зөвлөмж:

- Төгсөгчдийг уран бүтээлийн байгууллагад очоод хамт олонтойгоо “Баг” болж ажиллах чадвартай болгохын тулд тодорхой ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэх

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:Бүрэн хангасан

Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1 Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол, дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, хэрэгжилтийн тайлан
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин, судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багш суралцагчдын тооны зохистой харьцааны судалгаа /сүүлийн 5 жилээр/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаа
- Багш нарт олгосон урамшууллын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн дүрэм, СУИС-ийн захирлын тушаал, “Хөдөлмөрийн дотоод журам”, “СУИС-ийн багш, ажилтны ёс зүйн дүрэм” зэрэг баримт бичгүүдээр хүний нөөцийн бодлого, зохицуулалтыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.
- Дуулах урлаг хөтөлбөрт шаардлагатай мэргэжлийн хичээлийн багшийн орон тоог урьдчилан зарлаж, гэрээт болон дадлагажигч багш, нөөцөд бүртгэлтэй хүмүүс, шалгаруулалтад оролцогчдоос сонгон шалгаруулж авдаг.
- Мэргэжлийн салбарт ажиллаж байгаа уран бүтээлчид, дотоод, гадаадын их, дээд сургуульд нарийн мэргэжил эзэмшсэн мэргэжилтнийг сургуулийн бодлогоор багшаар урин ажиллуулдаг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын бүрэлдэхүүнд одоогийн байдлаар доктор зэрэгтэй нэг багш, докторантурт суралцаж, судалгаа хийж байгаа 4 багш ажиллаж байна.
- Одоогийн байдлаар хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимийн үндсэн багш 21, гэрээт багш 21, дадлагажигч багш 5, цагийн багш 12, бусад салбар, тэнхимийн багш 9, ерөнхий суурь хичээлийн 23 багш тухайн хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагааг зохион явуулж байна.

- Нэг багшид ноогдо оюутны харьцаа 1: 5-7 байгаа бөгөөд энэ нь багш оюутан бүрд хүрч ажиллах боломжийг бүрдүүлж байна.

Анхаарах асуудал:

- Хүний нөөцийн төлөвлөлтийг хийхдээ ажил мэргэжил, хэрэгцээний хүрээгээр нарийвчилсан судалгаа хийх
- Сургуулийн өнөөгийн нөөцийг ирээдүйн эрэлттэй харьцуулан, багш нарыг үндсэн багш нараас гадна гэрээт багшаар ажиллуулах, гэрээт багшийн үүрэг, оролцоог өндөржүүлэх, шинэ залуу багш нарыг бодлогоор сургаж бэлтгэх
- Багш нарын боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх, хөгжүүлэх ажлыг эрчимтэй, тасралтгүй явуулах
- Эрдмийн зэрэг цолтой багш нарын эзлэх хувийн жин дорвитой өсөхгүй байгаад анхаарах
- Докторантурт сурч байгаа болон докторын сургалтаа дүүргэсэн багш нараа дэмжин, судалгаа ажлаа амжилттай бичиж, хамгаалахад нь уран бүтээлийн цалинтай чөлөө олгох, эрдмийн ажлаа хамгаалах боломжийг нь бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Багш нарын ажил байдалтай танилцах явцад нэлээд багш нар соёл, урлагийн шинэлэг бүтээлүүдийг туурвисан, туурвиж байгаа, дуулах урлагийн чиглэлээр олон жил хуримтлуулсан туршлага, арга зүй байгаа нь харагдлаа. Үүнийг нь эрдэм шинжилгээний судалгааны эргэлтэд оруулж, судалгааны ажлын сэдэв, чиглэлийг тодорхой болгоод, эрдэм шинжилгээ, судалгааны нэгэн сэдэвт зохиол болгох бүрэн боломж харагдаж байгааг ажил хэрэг болгох нь зүйтэй.

6.2 Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа, судалгааны дагуу хийсэн ажлын баримт
- Төлөвлөгөө, тайлан
- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- СУИС-ийн захиргааны зөвлөлийн хурлын 2011 оны 12 сарын 21-ны шийдвэр, СУИС-ийн захирлын 2011 оны 11 сарын 27-ны өдрийн тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөр боловсруулан батлуулж, 3 үе шаттайгаар хэрэгжүүлэх, багшийг хөгжүүлэх, урт, богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулах зэрэг олон талт ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна.
- Багшийн хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого холбогдох дүрэм, журам шаардлагатай хөрөнгө оруулалтыг захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталгаажуулж, нэгдсэн төлөвлөгөө график гарган мөрдөж эхэлсэн.
- СУИС-ийн багшийн сургалтын үндсэн бичиг баримтын нэг болох Багшийн ажлын дэвтэртээ “Багшийн өөрийн хөгжлийн хөтөлбөр” гэсэн тусгай хэсэгтэй.
- Багш бүр өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө сургалт, эрдэм шинжилгээ, уран бүтээл олон нийтийн ажил, өөрийгөө хөгжүүлэх гэсэн шалгуур үзүүлэлтээр төлөвлөж, төсөвлөсөн зардлаа бичиж тэмдэглэн хөдөлмөрийн гэрээнд хавсралтаар оруулж, баталгаажуулан жилийн эцэст тэнхимийн хамт олны хурлаар хэлэлцүүлж, захиргааны зөвлөлөөр дүгнүүлдэг.
- Сургалтын бодлого зохицуулалтын албанаас багшийн хөгжил хөтөлбөрийн талаар судалгаа авч, хөтөлбөрийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, сайжруулалт хийхийн зэрэгцээ багшийн нарын мэргэжил, сургалтын арга зүй, гадаад хэлний мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн зохион байгуулж, ажлын байранд хөгжүүлэх боломжийг эрэлхийлж дотоодод сургалт, семинар зохион байгуулсан байна.
- “Багшийн хөгжил” хөтөлбөрийг (2024 он хүртэл) шинэчлэн боловсруулж, СУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталгаажуулсан.
- 2018-2019 оны хичээлийн жилээс багшийн тогтвортой хөгжлийг хангах, мэдлэг боловсролыг олон улсын түвшинд хүргэх, тасралтгүй бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, багшлах залгамж халааг дэмжих, сургалт судалгааг эрчимжүүлэх үүднээс Багшийн хөгжлийн багийг байгуулан ажиллаж эхэлсэн.
- “Дамжуулах үг” төсөл хэрэгжүүлэн, МУ-ийн хөдөлмөрийн баатар, АЖ, СУИС-ийн хүндэт доктор, профессор, Г.Хайдав, МУГЖ М.Найдалмаа нарын амьдрал, уран бүтээл, залууст захиж үлдээх үгийг кино болгон багшлах залгамж халааг бэлдэхийн зэрэгцээ судалгааны эргэлтэнд оруулах архивийг бий болгосон байна.

- “Өөдрөг өглөө” цуврал лекцийг 2018-2019 оны хичээлийн жилээс лхагва гарагт хоёр долоо хоног тутамд өглөө 06:45 минутаас зохион байгуулж хэвшүүлсэн байна.
- Үндсэн багшийг дотоодод магистрантур, докторантурт суралцахад сургалтын төлбөрийн 20-40 хувийг хөдөлмөрийн гэрээний дагуу зээл хэлбэрээр олгон хөнгөлөлт үзүүлж, одоогийн байдлаар 4 багш докторантурт суралцаж кредитээ цуглуулсан байна.

Анхаарах асуудал:

- Багш нараас авсан суралцах хэрэгцээний судалгааг хичээлийн жил тус бүрээр гарган зорилго дэвшүүлж, түүнийхээ үр дүнг тооцох
- Үндсэн багш нарын эзлэх хувийг нэмэгдүүлж, хүний нөөцийг бүрдүүлэх
- Багш нарыг хөгжихөд сургуулийн зүгээс анги танхимаар хангах
- Төгсөгчдөөс ирсэн саналд мэргэжлийн урлагийн байгууллагад ажиллахад суралцаж байх хугацаанд мэргэшүүлэх хичээлийн сургалтын орчин хүрэлцээгүй байдлаас 1 оюутан жилд 1 удаа тайзан дээр шалгалт өгч байгаа нь хангалтгүй байна. Учир нь төгсөөд тайзан дээр ажиллахад хүндрэлтэй бие барьсан байдалтай тайзтай харьцах чадвар дутмаг төгсдөг гэсэн санал шүүмжийг анхаарах.
- Ажил олгогч байгууллагаас “Ардын богино дуу”-ны мэргэжлээр төгсөгчид хэт хязгаарлагдмал хөрвөх чадвар тааруу гэх саналыг анхаарах.

Зөвлөмж:

- Их сургуулийн багш нарт тавигдах шаардлагад нийцүүлэх үүднээс өндөр хөгжилтэй орнуудад сурч боловсрон эрдмийн зэрэг хамгаалах залуу судлаачид багш нарын тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах
- Ахмад багш нарын сургалтын арга барилыг ном товхимол болгож үлдээх

6.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгаа
- Бодлогын баримт бичиг, дүрэм журам
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээ, хөтөлбөрт тусгагдсан байдал
- Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн тоо

- Зарцуулсан төсөв, тайлан

Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дуулах урлагийн тэнхимийн багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үндсэн чиглэлийг онол, арга зүйн тулгамдсан асуудал, сурах бичиг, гарын авлага туурвих, хэвлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд оролцох гэх зэргээр 8 чиглэлээр тодорхойлжээ.
- Шведийн музейд хадгалагдаж байгаа монгол ардын мартагдсан дуу, хөгжмийг сургалт, судалгаа, уран бүтээлийн эргэлтэд оруулах төсөл, “Галайхан” дуурилга, “Соёл урлагийн толь-сүвдан эрх” инновацийн төсөл амжилттай хэрэгжүүлсэн байна.
- 2013 оноос 2018 оны хооронд соёл, урлагийг дэмжих болон олон улсын дуурь, дуулалт жүжгийн 6 том төсөлд оролцжээ.
- 2014-2018 онд 18 багш эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл хэвлүүлжээ.
- 2016 онд багш Ц.Чулуунцэцэг “Уртын дууны тархалт, газар зүйн онцлог” сэдвээр Ph.D докторын зэрэг хамгаалсан бол 2013-2018 онд 12 багш магистрын зэрэг хамгаалжээ.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсвийг улсын захиалгат суурь болон хавсарга судалгааны төсөл, олон улсын хамтарсан төсөл, өөрийн дотоод санхүүжилт, шинжлэх ухаан, технологийн сан, БСШУСЯ-ны санхүүжилтээр бүрдүүлдэг бөгөөд 2014-2018 онд нийт 25,6 сая төгрөг зарцуулжээ. Санхүүжилтийн хэмжээ сүүлийн 2 жилд эрс өссөн үзүүлэлттэй байна.

Зөвлөмж:

- Эрдмийн зэрэг цолтой багш нарын эзлэх хувийг нэмэгдүүлэх

6.4 Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журам, хэрэгжилтийн тайлан
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Хөндлөнгийн үнэлгээний дүн

- Багшийн үнэлгээний дагуу авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний тайлан мэдээ
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар 2 жил тутам өөрийн үнэлгээний тайлан бичдэг. Өөрийн үнэлгээний тайланг сургалтын үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажил, уран бүтээл, нийгмийн үйлчилгээ, зөвлөх үйл ажиллагаа, хувь хүний хөгжил гэсэн үндсэн 3 чиглэлээр нийт 1000 оноогоор нарийвчлан дүгнэдэг.
- 2012, 2015, 2018 онд багш нарыг аттестатчилалд хамруулжээ.

Анхаарах асуудал:

- Оюутнаас авах судалгааны асуулгын оновчтой, зөв зохистой байдалд дүн шинжилгээ хийж, засан сайжруулдаг байх.

Зөвлөмж:

- Аттестатчилалд хамрагдсан багш нарын дүгнэгдсэн оноог тайланд тусгажээ. Аттестатчиллын байдлаас дүн шинжилгээ хийхэд багш нар ямар үзүүлэлт, шалгуур дээр оноо сайн авч байгаа болон ямар үзүүлэлтийг тааруу хангаж байгаад дүн шинжилгээ хийдэг байх хэрэгтэй.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1 Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем.
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдмийн зөвлөлийн 2016 оны 12-р сарын 16-ны өдрийн хурлын 18 тоот тушаалаар “Дотоод чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх” хөтөлбөр хэрэгжүүлэх шийдвэр гаргасан.
- Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд “Дотоод үйл ажиллагааны чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх” ажлын СУИС-д тохирох чанарын баталгаажуулалтын арга зүй, шалгуур үзүүлэлтийг боловсруулах, үр дүнг гарын авлага болгон бэлтгэх ажлын хэсгийг 2017 оны 1-р сарын 05-ны өдрийн 2/09 тоот захирлын тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг баталсан байна.
- Чанарын баталгаажуулалтын тогтолцоог бий болгох зорилгоор 2016 оноос 3 үе шаттай (Чанарын шалгуур үзүүлэлтийг тогтоох дүрэм, журмыг шинэчлэх, Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, соёлыг төлөвшүүлэх, Чанарын удирдлагын тогтолцооны хэрэгжилтэд үнэлгээ өгөх, хяналт сайжруулалтын үе) арга хэмжээг авч хэрэгжүүлэх бодлого төлөвлөжээ.
- Дээрх 3 үе шатанд суралцахуйн чанар, багшлахуйн чанар, дэд бүтэц, нөөцийн хүртээмж, чанар, академик болон ажил олгогчдын хэрэгцээнд нийцэж буй эсэх, гадаад шаардлагад нийцэж буй эсэх гэсэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлжээ.
- Чанарын дотоод баталгаажуулалтын хөтөлбөрийн хүрээнд хичээлүүдийн чанарыг улирлын төгсгөл бүрд оюутнаас UNICULTURE-аар дамжуулан судалгаа авах, багш нарыг удирдлага үнэлэх, бусад багш нар үнэлэх, хичээлийн кодын давхардлыг үнэлэх зэрэг ажлуудыг хийж эхэлжээ.
- Төгсөгч оюутнуудыг ажлын байраар мэргэжлийн урлагийн байгууллагууд болон бусад урлаг соёлын байгууллагуудаас судалгаа авч, тайланг СУИС-ийн СБЗГ-т хүлээлгэн өгчээ.

Анхаарах асуудал:

- Чанарын дотоод баталгаажуулалтын талаар тодорхой бодлого, дүрэм, журамтай байгаа боловч энэ нь тухайн хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж дээрээ хэвшил болон тогтсон байнгын үйл ажиллагаа дутмаг байгааг цаашид анхаарах.
- Чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу багш нар болон сургалтын хөтөлбөрийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах талаар онцгойлон анхаарах.

Зөвлөмж:

- Чанарын дотоод баталгаажуулалтын үйл ажиллагааг багш нарын ажлыг удирдлага үнэлэх шалгах гэхээсээ илүү багш нарт тулгамдаж буй асуудлыг нь олж, түүнд нь зөвлөн туслах, чиглүүлэх, хамтран ажиллах урам зоригийг нь бадраах, дэмжих хөшүүрэг болгох тал дээр сургуулийн удирдлагууд, алба, нэгжүүд санаачилгатай ажиллах нь зүйтэй.

7.2 Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 1990-2018 оны байдлаар Дуулах урлаг хөтөлбөрөөр нийт 981 оюутан төгссөнөөс 913 нь хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамрагдсан байна. Тэдний 53.8% буюу 491 төгсөгч нь эрхэлсэн ажилтай, 30.2% буюу 276 төгсөгч чөлөөт уран бүтээлч, 11.8% буюу 108 төгсөгч хувиараа бизнес эрхэлдэг, 2.3% буюу 21 төгсөгч суралцаж байгаа, 1.9% буюу 17 төгсөгч одоогоор тодорхой эрхэлсэн ажилгүй байна.
- 2013-2018 онд 372 оюутан төгссөнөөс 301 буюу 80.9% төгсөгчдийг хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамруулан, ажил эрхлэлтийн байдлыг байгууллагын төрөл болон мэргэжлээрээ, мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлтээр нарийвчлан судалж, дүн шинжилгээ хийсэн нь сайшаалтай байна. Уг судалгаагаар 301 төгсөгчдийн 230 буюу 76.4% нь мэргэжлийн дагуу ажиллаж байгаа нь тогтоогджээ.
- Дуулах урлаг хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг ажил олгогчдын үнэлгээний түвшинтэй харьцуулан, ямар ур чадвар нь ойролцоо, ямар нь зөрүүтэй байгааг тогтоосон нь үр дүнтэй судалгаа болжээ.

- ХУС-ийн төгсөгчид мэргэжлээрээ ажиллахад шаардлагатай ерөнхий ур чадварын харьцуулсан судалгааг 1990 оноос өмнөх болон хойших онуудаар гарган, улмаар Дуулах урлаг хөтөлбөрийн төгсөгчдийн мэргэжилтэй холбоотой мэдээлэл бүрдүүлэлтийн байдлыг үзүүлэлт бүрээр дүн шинжилгээ хийсэн нь ололттой байна.
- 2013-2018 оны хоорондох төгсөгчдийг ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулсан хамгийн урт хугацааг судалж үзэхэд төгсөгчдийн ажлын байраар хангагдах хугацаа 6 сараас ихгүй байна. Харин сургууль төгссөнөөс хойших бүх төгсөгчид ажил эрхлэх хүртэл 1 жилээс хэтрэхгүй хугацаанд ажлын байраар хангагдсан үр дүн гарчээ.
- Дуулах урлаг хөтөлбөрөөр төгсөгчид нь мэргэжлийн онцлогоос шалтгаалан хувиараа буюу чөлөөт уран бүтээл хийх нь элбэг байна.
- Хөтөлбөрт оролцогч талуудаас 2014, 2018 онд тус бүр 2 удаа санал асуулгын судалгаа авсан байна.
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааг 6 үзүүлэлтээр 2014, 2018 онд тус бүр авч харьцуулахад сэтгэл ханамжийн үнэлгээ сайжирсан үзүүлэлт байна.
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг зөвхөн 2018 онд авсан бөгөөд уг судалгаагаар оюутнуудын бие даах чадвар, мэргэжлийн мэдлэгийн түвшин, төлөвлөлт, зохион байгуулалт зэрэг чадварууд 80% -аас дээш үзүүлэлттэй дүгнэгджээ.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг цаашид зөвхөн төгсөгчийн болон ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаагаар бус хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүйгээр нь нарийвчлан боловсруулан, дүн шинжилгээ хийж хэвшихэд анхаарах

Зөвлөмж:

- Ажил олгогч нартай хамтын ажиллагааг улам өргөжүүлэн хөгжүүлж, оюутан суралцагчид бие дааж дадлага сургуулилт хийх, карьер өсөх боломжийг бүрдүүлэхэд нь хамтран ажиллах

7.3 Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр

- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрсөнийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.
- Дотоод гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал:Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Дуулах урлаг мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр нь 2012 онд сургалтын хөтөлбөрийн шалгуур, шаардлагыг хангасан тухай Соёл, урлагийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлийн шийдвэрээр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн байна. Мэргэжлийн зөвлөлийн 3 гишүүний өгсөн санал, зөвлөмж, дүгнэлтийг хөтөлбөрийн шинэчлэлд тусган хэрэгжүүлсэн байна. Жил бүр хөтөлбөрийн ахиц, дэвшлийн тайланг өгч, тогтмол тайлагнаж иржээ.
- 2013-2018 онд төгсөгчдийн тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдөж буйн нэг хэлбэр нь төрөөс хүртэж буй гавьяа шагнал байна. Энэ хугацаанд нийт төгсөгчдөөс 20 төгсөгч МУСТА болжээ.
- Төгсөгчдөөс олон улсын болон улсын чанартай уралдаан тэмцээнд гаргасан амжилтуудыг 2013 оноос эхлүүлэн жагсаалтаар гаргажээ.
- Дуулах урлаг хөтөлбөрийн багш нар нийслэл, хөдөө орон нутгийн театр, чуулгад мэргэжил дээшлүүлэх болон түргэвчилсэн сургалтуудыг НБГ, БСШУЯ-тай хамтран жил бүр хэрэгжүүлдэг байна.
- Дуулах урлаг мэргэжлийн бакалаврын түвшний сургалтаас 2013-2018 онд ахисан түвшний сургалтад нийт 31 төгсөгч хамрагдсан байна.
- ОХУ-ын П.Чайковскийн нэрэмжит хөгжмийн дээд сургууль, Гнесины нэрэмжит хөгжмийн академи, Дорнод Сибирийн Соёл урлагийн дээд сургууль, БНСУ, БНХАУ, ӨМӨЗО зэрэг улс орны ижил төстэй урлагийн сургуулиудтай багш, оюутан солилцох, хамтарсан сургалт зохион байгуулах зэргээр ажиллаж байгаа нь тухайн хөтөлбөр олон улсад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд байгааг илэрхийлж байна.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ:Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ:

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
Дүгнэлт		<p>“Дуулах урлаг” хөтөлбөрт сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх 7 үндсэн шалгуур, 26 дэд шалгуур бүрээр үнэлгээ, дүгнэлт хийхэд 1-р шалгуурын 3 дэд шалгуураас 1 нь, 2-р шалгуурын 3 дэд шалгуураас 1 нь, 4-р шалгуурын 5 дэд шалгуураас 2 нь, 5-р шалгуурын 5 дэд шалгуураас 2 нь тус тус “хэсэгчлэн хангасан” гэсэн үнэлгээ авлаа. “хангаагүй” үнэлгээг аваагүй болно. Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан үнэлгээг харьцуулахад бүрэн хангасан дэд шалгуур нь-20, хэсэгчлэн хангасан дэд шалгуур нь 6 байгаа бөгөөд ерөнхий үнэлгээгээр 7 үндсэн шалгуурууд нь бүгд “БҮРЭН ХАНГАСАН” үнэлгээ, дүгнэлттэй байна.</p>			

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн, шинжээчийн баг СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургуулийн “Дуулах урлаг” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Урлаг, хүмүүнлэгийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Ц.Дэлгэрсайхан/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг/Ч.Чинзориг/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Ш.Цогтгэрэл/



**СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХӨГЖМИЙН УРЛАГИЙН СУРГУУЛЬ**

15140 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 26, Утас: 32 88 45, Факс: (976-11) 32 52 05

2019.06.12 № 01/159
танай _____-ны № _____-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

Тус сургуулийн Дуулах урлаг хөтөлбөрийн магадлан
итгэмжлэлийн шинжээчдийн гаргасан тайлантай танилцаж
санал нэгтэй байгаагаа илэрхийлье.



[Signature] Г.ГАНЦЭЦЭГ

C/My doc/alban toot/

V. Оролцогчдын нэрс

I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	А.Дашпэлжээ	Багш	Монгол Улсын Ардын жүжигчин	45	Дуулах ур чадвар /Дуурийн дуу/
2	Л.Халиунсүрэн	Концертмейстер багш	Монгол Улсын гавьяат жүжигчин	44	Дуулах ур чадвар /Концертмейстер/
3	Б.Батболд	Багш	Монгол Улсын гавьяат жүжигчин,	23	Дуулах ур чадвар /Уртын дуу/
4	А.Долгор	Багш	Монгол Улсын Ардын жүжигчин	40	Дуулах ур чадвар /Дуурийн дуу/
5	С.Цогтсайхан	Багш	Монгол Улсын гавьяат	23	Дуулах ур чадвар /Уртын дуу/
6	Л.Чулуунчимэг	Багш	Монгол Улсын гавьяат жүжигчин	41	Дуулах ур чадвар /Ардын богино дуу/
7	Н.Түвшинжаргал	Концертмейстер багш	Магистр	20	Дуулах ур чадвар /Концертмейстер/
8	Б.Алтанжаргал	Концертмейстер багш	Магистр	7	Дуулах ур чадвар /Концертмейстер/
9	Б.Цэдвээ	Багш	Магистр	21	Дуулах ур чадвар /Орчин цагийн дуу/
10	Б.Өсөхбаяр	Концертмейстер багш	Магистр	4	Дуулах ур чадвар /Концертмейстер/

II. Ажил олгогчид

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Н.Мөнгөнчимэг	Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга	Хормейстер
2	Б.Ганхуяг	Хилийн Цэргийн Дуу Бүжгийн чуулга	Дарга
3	Д.Содномдаржаа	Сүлд чуулга	Дууны багш

IV. Төгсөгчид

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Х.Мягмарсүрэн	2015	Дуурь бүжгийн эрдмийн театр	Дуучин
2	Д.Сайзанмаа	2015	Үндэсний урлагийн их театр	Дуучин
3	Г.Отгонзул	2014	Үндэсний урлагийн их театр	Дуучин
4	А.Бадамсүрэн	2016	Төмөр замын чуулга	Дуучин
5	Ж.Хулан	2018	Сүлд чуулга	Дуучин

IV. Оюутнууд

№	Овог нэр	Чиглэл	Курс	Үндсэн захиргаа,	Утас
1	О.Урьхан	Дуурийн дуу	IV курс	Оюутны дотуур байранд /ӨМӨЗО-ны суралцагч/	80260915
2	М.Роза	Дуурийн дуу	IV курс	Баян-Өлгий аймгийн харьяат, байр түрээсэлдэг	94127765
3	Н.Оюунбилэг	Уртын дуу	III курс	Төв аймгийн харьяат, айлд	89978358
4	П.Долзодмаа	Ардын богино дуу	III курс	Говь-Алтай аймгийн харьяат, дотуур байранд	95911277
5	Б.Пунсанлхагва	Ардын богино дуу	III курс	Хөвсгөл аймгийн харьяат, айлд	91389938
6	Б.Отгонтуяа	Уртын дуу	IV курс	Хөвсгөл аймгийн харьяат, айлд	88387020
7	Э.Дуламдорж	Уртын дуу	IV курс	Өвөрхангай аймгийн харьяат, ахындаа	99604583
8	Д.Алгирмаа	Уртын дуу	IV курс	Дундгов аймгийн харьяат, айлд	80498007
9	Ж.Мөнх-Эрдэнэ	Уртын дуу	IV курс	Говь-Алтай аймгийн харьяат, айлд	99605089
10	Б.Сурмаажав	Уртын дуу	IV курс	Хэнтий аймгийн харьяат, ахындаа	86465090
11	Б.Сэржээ	Уртын дуу	II курс	Баянхонгор аймгийн харьяат, айлд	88368182
12	Г.Долгормаа	Уртын дуу	II курс	Говь-Алтай аймгийн харьяат, гэрт	85629263
13	М.Мягмардорж	Уртын дуу	II курс	Төв аймгийн харьяат, айлд	90189600
14	Б.Наранзаяа	Уртын дуу	I курс	Өвөрхангай аймгийн харьяат, айлд	80063917
15	Э.Сувд-Эрдэнэ	Уртын дуу	I курс	Увс аймгийн харьяат, айлд	88454111
16	А.Оюу-Эрдэнэ	Орчин цагийн дуулаач	III курс	Өвөрхангай аймгийн харьяат, айлд	99482280
17	Л.Балжинням	Орчин цагийн дуулаач	III курс	Багануурын харьяат, дотуур байранд	99535120

VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/

VII. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

XI. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/